

# ДОТООДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ



2025.12.01

## Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

## ТОВЧ

- Эрдэнэс Таван Толгойн нүүрсний эксдорт эрчимжлээ
- QPAY хувьцааны ханш тогтвортой байдлаа хадгалсаар байна.
- Голомт банкны хувьцааны ханш тогтворжлоо.

## МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	4.87%	0.92%	25.47%
MSE A	1.92%	-0.01%	20.27%
MSE B	2.18%	-0.97%	34.89%

2025/11/24 – 2025/11/28

## Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Тоо ширхэг
QPAY	4,625,374,907.53
KHAN	542,987,497.00
MGLA	298,217,960.00
TDB	213,065,820.00
GLMT	92,245,250.00

2025/11/24 – 2025/11/28

## Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
HRL	65.00	34.60%
SIL	33.35	15.00%
HSG	31,740.00	15.00%
SUN	433.00	14.85%
UID	4,077.00	9.78%

2025/11/24 – 2025/11/28

2025 он 12-р сарын 01

Зах зээлийн  
үнэлгээ тэрбум ₮

13,245

ТОП-20 индекс

51,557

MSE A

19,432

MSE B

14,596

## МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

5.6%

2025 - III улирал

Инфляц

9.0%

2025-09 сар

ГВУН(сая\$)

5,911.03

2025-10 сар

Бодлогын

хүү

12.0%

ЗГ-ын бондын

өгөөж

6.6%

USD/MNT

3,553.58

2025-11-30



## Эдийн засгийн мэдээлэл

### ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙН НҮҮРСНИЙ ЭКСПОРТ ЭРЧИМЖЛЭЭ

Монгол Улсын Засгийн газраас компанид ногдуулсан Онцгой дэглэмийн хугацаа дууссаны дараа буюу 10-р сарын 23-наас хойш компани үйл ажиллагаагаа идэвхтэй сэргээж эхэлсэн талаар шинжээчид онцолж байна. Шинээр томилогдсон гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч ажлаа авснаас хойш 31 удаагийн арилжаагаар 2.78 сая тонн нүүрсийг 206.4 сая ам.долларын үнээр худалдаалсан байна.

Тус экспортын сэргэлт нь гадаад валютын орлогыг нэмэгдүүлж, Монголбанкныхаа валютын нөөцийг өсгөхөд түлхэц үзүүлж байгаа тул төгрөгийн ханшийг тогтворжуулахад чухал нөлөө үзүүлж байна гэж салбарын шинжээчид дүгнэжээ.

Мөн 11-р сард гүйцэтгэсэн борлуулалт энэ оны хамгийн өндөр үзүүлэлттэй байв. Тодруулбал: 25 удаагийн биржийн арилжаанд 2 сая гаруй тонн нүүрсийг 159.0 сая ам.доллараар борлуулсан нь 2025 онд хийсэн хамгийн өндөр дүнтэй арилжаа болж бүртгэгджээ.

Ингэснээр компанийн шинэ удирдлагын баг экспортын гүйцэтгэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогоо богино хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлж чадсан гэж салбарынхан үнэлж байна.

Харин 2025 оны эхний 10 сарын хугацаанд 15.7 сая тонн нүүрсний борлуулалт хийгдсэн бөгөөд энэ нь он гарсаар тогтвортой экспортын гүйцэтгэл хадгалагдаж буйг харуулж байна. Түүнчлэн 2025 оны аравдугаар сард нүүрсний дуудлага худалдааны дундаж үнэ нэг тонн тутамд 86 ам.доллар, харин хэлцлийн дундаж үнэ 75 ам.доллар байв.

Нүүрсний төрөл, чанарын ялгаатай байдлаас шалтгаалж тухайн сард хэлцлийн хамгийн доод үнэ 41 ам.доллар, хамгийн дээд үнэ 166 ам.долларт хүрсэн нь зах зээлийн нөхцөл байдал, бүтээгдэхүүний ангиллаас шалтгаалан үнийн хэлбэлзэл өндөр байгааг илтгэж байна.

### ВАЛЮТЫН ХАДГАЛАМЖИЙН ӨСӨЛТ ВАЛЮТЫН ХАНШИД 2 ТАЛЫН НӨЛӨӨТЭЙ

Эерэг тал:

Гадаад валютын нөөцийг арилжааны банкуудын түвшинд нэмэгдүүлж, гадаад төлбөрийн чадварт дэмжлэг үзүүлдэг.

Валютын гүйлгээний хангамжийг сайжруулж, санхүүгийн тогтвортой байдлыг хадгална.

Сөрөг тал:

Иргэдийн валютын хуримтлал нэмэгдэх нь төгрөгөөс доллар руу хөрөнгө шилжих хандлага хүчтэй байгааг харуулж, валютын ханшид өсөлтийн дарамт үзүүлдэг.

Хэрэв эдийн засгийн тодорхой бус байдал, импортын дарамт зэрэг хүчин зүйл үргэлжилбэл ам.долларын ханш дахин өсөх эрсдэлтэй.



## Зах зээлийн мэдээлэл

### ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН 8.3 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН БАГЦЫН АРИЛЖАА ХИЙГДЛЭЭ

График 1. QPAY хувьцааны ханшийн график




QPAY хувьцааны ханш өнгөрсөн долоо хоногт 3 гаруй хувиар өсөж, 9-р сараас хойш 15 орчим хувиар өсөөд байна. Цаашдаа ханшийн зорилтот түвшинг 260₮ гэж таамаглаж байгаа бөгөөд үнэлгээний үзүүлэлт хамгийн бага хувьцаануудын нэг хэвээр байна. Мөн өнгөрсөн долоо хоногт 8.5 тэрбум төгрөгийн багцийн арилжаа хийгдэж, нийтдээ 9.05 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний арилжаа хийгдлээ.

### ГОЛОМТ БАНКНЫ ХУВЬЦААНЫ ХАНШ ТОГТВОРЖЛОО



## ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

### Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.

### ВАЛЮТЫН ХАНШИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Хэрэв нүүрсний үнэ 10%-иар буурч экспортын орлого 800 сая ам.доллараар багасна гэж үзвэл: 2026 онд инфляц 0.7 нэгж хувиар нэмэгдэхтэй уялдан төгрөгийн ханш ам.долларын эсрэг 3-5% орчим сулрах магадлалтай.

График 1. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш

